БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.АМАРТҮВШИН

# 312 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ГАДНА ТОХИЖИЛТ /ХУД, 4 ДҮГЭЭР ХОРОО/-ЫН АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 9-р сарын 22-ны өдөр № 01 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Зураг төсөл боловсруулах үндэслэл | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 8-ний өдрийн А/09 дүгээр захирамж |
| 2. | Байршил, эдэлбэр газрын хэмжээ | - Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт, 312 дугаар цэцэрлэг |
| 3. | Зориулалт, хүчин чадал | - Тохижилт |
| 4. | Төсөл гүйцэтгэх хугацаа | - Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно |
| 5. | Зураг төслийн иж бүрдэл | <u>Баримт бичгийн иж бүрдэл:</u><br>- Инженер геологийн дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/<br>- Байр зүйн дэвсгэр зураг /газар доорх болон дээрх шугам сүлжээний тодруулгын хамт, шаардлагатай тохиолдолд/;<br>- Мэргэжлийн хяналт болон Онцгой байдлын дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/<br>- Магадлалын дүгнэлт /хавсралтын хамт/;<br><u>Ажлын зургийн иж бүрдэл:</u><br>- Иж бүрэн ажлын зураг; /шаардлагатай тохиолдолд/<br>- Барилгын нэгдсэн төсөв /Тооцооны ESTIMATOR-PRO программ/;<br><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u><br>- Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх;<br>- Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага:<br>o Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх;<br>o Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх; |
| 6. | Төсөл боловсруулах үе шат | Ажлын зураг |
| 7. | Төсөл гүйцэтгэх байгууллага | - Барилга хот байгуулалтын яамны сайдын тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын Барилга байгууламжийн угсралтын ажлын тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд; |

| | | |
|---|---|---|
| 8. | Төслийн захиалагч | - Нийслэлийн Боловсролын газар; |
| 9. | Онцгой нөхцөл | - Нийслэлийн 312 дугаар цэцэрлэгийн одоо байгаа хашаа болон цахилгааны дэд өртөө шилжүүлэх /шаардлагатай тохиолдолд тохижилт хийх / |

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
СХОХ-ИЙН ДАРГА ..................... /Д.БАТСҮХ/

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗТХ-ИЙН ДАРГА ..................... /Б.ЛХАГВАЖАВ/

БОЛОВСРУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР ..................... /Б.БАТ-ОРГИЛ/

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
СХОХ-ИЙН БАРИЛГА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
МЭРГЭЖИЛТЭН ..................... /Д.ИРМҮҮНЗАЯА/

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр Дугаар А/09 Улаанбаатар хот

Иргэнд нөхөх олговор олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1, 104.3 дахь хэсэг, Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 42, 43 дугаар зүйл, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 222 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам"-ын 5.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 122, 125 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01-13/3 дугаар албан бичгээр ирүүлсэн саналын дагуу Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг "Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам, замын барилга (1 дүгээр хэсэг гүүрийн барилгын ажил)" төсөл, арга хэмжээний нөлөөлөлд өртсөн иргэнд олгох нөхөх олговрын хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан 1 (нэг) нэгж талбарын нөхөх олговрыг санхүүжүүлэхэд шаардлагатай 52,839,000 (тавин хоёр сая найман зуун гучин есөн мянга) төгрөгийг "Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний шинэчилсэн жагсаалт"-ын "108"-д заасан "Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл арга, хэмжээний газар чөлөөлөлт, нөхөх олговор, Улаанбаатар хот"-ын хөрөнгөөс холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын тасаг (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Энхжин)-т, нөхөх олговрын гэрээг холбогдох хууль, журмын дагуу байгуулж, гэрээнд заасан хугацаанд газар чөлөөлөх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Батзориг)-нд тус тус даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (П.Сайнзориг)-д үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1110200033

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн A/03 дугаар захирамжийн хавсралт

"НААДАМЧДЫН АВТО ЗАМААС ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ ХҮРТЭЛХ 2.8 КМ АВТО ЗАМ ГҮҮРИЙН БАРИЛГЫН АЖИЛ"
(ХАН-УУЛ ДҮҮРЭГ 4 ДҮГЭЭР ХОРОО) ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ИРГЭДЭД ОЛГОХ НӨХӨХ ОЛГОВРЫН ХЭМЖЭЭ

| Д/д | Газар эзэмшигч, өмчлөгчийн нэр /регистрийн дугаар/ | Хаяг | Нэгж талбарын дугаар | Үндсэн талбайн хэмжээ /м2/ | Эдэлбэрийн хэлбэр | Нөлөөлөлд өртсөн газрын | | | Хөрөнгийн нөхөх олговрын үнэлгээ /төгрөг/ | | | Нийт нөхөх олговор /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гэрчилгээний дугаар | Хэмжээ /м2 | Үнэлгээ /төгрөг/ | Гэрчилгээний дугаар | Үл хөдлөх хөрөнгө | Эд хөрөнгө | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Хан-Уул дүүрэг 4 дүгээр хороо "Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэх авто зам, замын барилга /1 дүгээр хэсэг гүүрийн барилгын ажил/" | | | | | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн боловсролын газар 9077065 | Хан-Уул дүүрэг 4 дүгээр хороо Наадамчдын зам | 1780912251 | 5,000 | Эзэмших | Э-2206003223 | - | - | | - | 52,839,000 | 52,839,000 |
| Нийт | | | | 5,000 | | | 0 | - | | - | 52,839,000 | 52,839,000 |